

Golomt Capital[®]

ДЭЛХИЙН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**

2026.05.11

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ


ТОВЧ

- ХНС-ийн ээлжит хурал болж хүүг хэвээр хадгаллаа.
- АНУ-д 4-р сард 115 мянган шинэ ажлын байр нэмэгдэж, хөдөлмөрийн зах зээл хүлээлтээс хүчтэй хэвээр байгааг харууллаа.
- S&P 500 индекс 7,400 нэгжид хүрлээ.
- Технологийн компаниуд AI болон дата төвийн хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж байна.
- Trump болон Xi Jinping нарын уулзалт дэлхий дахины анхаарлын төвд байна.
- Хоёр их гүрний ерөнхийлөгч нар 5-р сарын 14-15 хооронд уулзана.
- Хятадын технологийн компаниудын тайлан анхаарлын төвд байна.
- Уулзалтаар тариф, Ираны дайн, хиймэл оюун ухаан, газрын ховор элементийн экспортын хязгаарлалт, Тайванийн асуудал зэргээр өргөн хүрээнд ярилцана.



S&P 500 индексийн 2026 оны таамаглал

Capital Economics	8,000
Deutsche Bank	8,000
Wells Fargo	7,800
Morgan Stanley	7,800
Goldman Sachs	7,750
RBC	7,750
JPMorgan	7,500
HSBC	7,500
UBS	7,500
Barclays	7,400
Bank of America	7,100
Дундаж	7,645





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2026.05.04-05.10

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ХҮЛЭЭЛТЭЭС ХҮЧТЭЙ ГАРАВ

АНУ-ын 4-р сарын хөдөлмөр эрхлэлтийн тайлан зах зээлийн хүлээлтээс давж, 115 мянган шинэ ажлын байр нэмэгдсэн байна. Ажилгүйдлийн түвшин 4.3%-д тогтвортой хадгалагдсан нь хөдөлмөрийн зах зээл сулраагүйг илтгэлээ. Энэхүү үзүүлэлт нь АНУ-ын эдийн засгийн идэвхжил харьцангуй тогтвортой байгааг харуулсан ч инфляцын дарамт бүрэн арилаагүй гэсэн болгоомжлолыг нэмэгдүүлэв. Үүний дараа АНУ-ын Засгийн газрын бондын өгөөж өсөж, хөрөнгө оруулагчид бодлогын хүү өндөр түвшинд удаан хадгалагдаж болзошгүй гэж үзэж эхэлсэн байна.

ТЕХНОЛОГИЙН КОМПАНИУДЫН ТАЙЛАН АНУ-ЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИВ

АНУ-ын хөрөнгийн зах зээл өнгөрсөн долоо хоногт хүчтэй өсөлттэй байж, гол индексүүд шинэ дээд түвшинд хүрэв. S&P 500 индекс анх удаа 7,400 нэгжид хүрч, 3-р сарын 30-наас хойш +17.2%-иар өсөөд байна. Ингэснээр АНУ-ын хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 10 их наяд ам.доллараар нэмэгдэв. Ялангуяа хиймэл оюун ухаан, чип үйлдвэрлэл болон технологийн салбарын компаниудын улирлын тайлан зах зээлийн өсөлтийг үргэлжлүүллээ. NVIDIA, Tesla, Intel зэрэг компаниудын хувьцаа өссөн бөгөөд Intel компанийн Apple-тай чип үйлдвэрлэлийн хамтын ажиллагааны мэдээллийн дараа хувьцаа нь огцом өсөв. Хөрөнгө оруулагчид AI дэд бүтэц, дата төв болон өндөр хүчин чадлын чипийн эрэлт цаашид өндөр хэвээр хадгалагдана гэж үзэж байна.

AI БА ДАТА ТӨВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ СЭДЭВ ХЭВЭЭР БАЙНА

Технологийн компаниудын тайлангаас харахад хиймэл оюун ухааны эрэлт эрчимтэй өссөөр байгаа бөгөөд компаниуд дата төв, сервер, өндөр хүчин чадлын GPU болон AI дэд бүтцэд их хэмжээний хөрөнгө оруулалт хийж байна. Microsoft, Meta болон Amazon зэрэг компаниуд AI хөгжүүлэлтэд зарцуулах хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж буйгаа онцолсон нь технологийн салбарын өсөлтийг дэмжив. Үүний зэрэгцээ эрчим хүчний хэрэглээ болон дата төвийн хүчин чадлын асуудал хөрөнгө оруулагчдын анхаарлыг татаж эхэлсэн байна.





Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2026.05.04–05.10

CSI 300 индекс долоо хоногийн хугацаанд 1.34%-иар өссөн бол Shanghai Composite Index юанийн ханшаар тооцоход 1.65%-ийн өсөлт үзүүлсэн байна. Мөн Hang Seng Index 2.39%-иар өсөж, технологи болон хэрэглээтэй холбоотой зарим хувьцаанууд өсөлтийг тэргүүлээ.

ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭРЭЛТ ӨНДӨР ХЭВЭЭР БАЙНА

Хятадын үйлчилгээний салбарын идэвхжил 4-р сард хүлээлтээс давсан өсөлттэй гарчээ. тарифын тодорхойгүй байдал болон гадаад эрэлт сул хэвээр байгаа ч дотоодын эдийн засгийн идэвхжил харьцангуй тогтвортой байгааг харуулж байгаа юм. Мөн инфляц 4- сард 1.2%-иар өссөн нь дефляцийн урт хугацааны дарамт сулрах дохио болж байна.

TRUMP БОЛОН XI JINPING НАРЫН УУЛЗАЛТ ДЭЛХИЙ ДАХИНЫ АНХААРЛЫН ТӨВД БАЙНА

5-р сарын 14-15 хооронд болох АНУ-ын Ерөнхийлөгч Donald Trump болон БНХАУ-ын дарга Xi Jinping нарын Бээжинд хийх уулзалтыг дэлхийн улс орнууд анхааралтай ажиглаж байна. Хоёр их гүрний төрийн тэргүүнүүдийн уулзалтаар худалдааны түр эвлэрлийг сунгах, мөн хөдөө аж ахуйн худалдан авалт, хиймэл оюуны аюулгүй байдал, нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдлын талаар боломжит тохиролцоонуудыг хэлэлцэхээр төлөвлөгдөж байна.

Харин эсрэгээрээ зөрчил гүнзгийрвэл дэлхийн худалдаа, эдийн засгийн өсөлтөд том дарамт болж, геополитикийн тогтворгүй байдал урт хугацаанд үргэлжлэх эрсдэлтэй.

ТЕХНОЛОГИЙН АВАРГА КОМПАНИУДЫН ТАЙЛАН ТАНИЛЦУУЛАГДАНА

Технологийн хувьцаанууд хүчтэй өсөлттэй байгаатай зэрэгцэн Хятадын технологийн компаниудын тайлан энэ долоо хоногт заарлагдан. JD компанийн тайлан 5-р арын 12-нд, Alibaba компанийн тайлан 5-р сарын 13 өдөр тус тус танилцуулагдана.

HKEX:BABA (BUY)



HKEX:981 (HOLD)



Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning									
May 04, 2026									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	
NCLH NORWEGIAN CRUISE LINE	PLTR Palantir	SHOP shopify	AMD AMD	DIS Walt Disney	COHR COHERENT	ACMR ACM RESEARCH	CRWV CW CoreWeave	WEN Wendy's	
BRK.B BERKSHIRE HATHAWAY INC	ON onsemi	PPPL PayPal	LITE LUMENTUM	NOVO Novo Nordisk	IONQ IONQ	ARKO ARKO	IREN IREN	DIBS DIBS	
TSN Tyson	RIG Transocean	ET ENERGY TRANSFER	SMCT SUPERMICR	HUT8 HUT 8	AXON AXON	BXSL Blackstone Secured Lending	OPEN Opendoor	WULF TERAWULF	
ADCT ADC THERAPEUTICS	DUOL duolingo	FSV fiserv.	ANET ARISTA	UBER Uber	ARM arm	CELH CELSIUS	AOI AOI	ENB ENBRIDGE	
AXSM axsome	PINS Pinterest	PFE Pfizer	AMC amc	KHC Kraft Heinz	BROS Dutch Bros	DDOG DATADOG	LIBR mercado libre	DCH DAUCH	
COGN cogent	FNB fabrinet	DOCN DigitalOcean	ALAB AsferaLabs	CVS CVS Health	APP APPROVIN	MCD McDonald's	COIN coinbase	AIRS AirSculpt	
KRYV Krystal	BWXT BWXT Technologies, Inc.	CIPR Cipher Mining	HL Hera Mining Company	EVO evotec	FSLY fastly	IOWA IOVANCE	COIN coinbase	AGN Algonquin	
HESS Hess Midstream	GRAB Grab	KKR KKR	MSTR Strategy	AMCR amcor	SNAP Snap Inc.	FLWS 1800 flowers.com	COIN coinbase	MSGS MAGNIFICENT MEDIA	
CNA CNA	STRL STERLING	HOG HARLEY-DAVIDSON	TEM TEMPUS	CR carter's	ALB ALBEMARLE	BLSKY BLACK SKY	COIN coinbase	EMBJ EMBRAER	
PWV PINNACLE WEST	VOYR VOYAGER	AEP AMERICAN ELECTRIC POWER	NVTS Navitas	OSCR OSCAR	KROS KROGER	UUUU EF ENERGY FUELS	REDCAT REDCAT	ARBOR ARBOR	

http://eps.sh/cal © 2026 Earnings Whispers

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning									
May 11, 2026									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	
CRCL CIRCLE	HIMS hims hers	OBTB D:wave	OKLO OKLO	NEBS NEBIUS	CSCO CISCO	ONDS ONDAS NETWORKS	AMAT APPLIED MATERIALS	SPRY ARS PHARMA	
CEG Constellation	ASTS AST SpaceMobile	KOPN KOPIN	KRNN KARMAN	BABA Alibaba Group	ENOV ENOVIX	BN Brookfield	NU NU	HTHT 华住 WORLD	
MNOV monday.com	RIGI rigetti	AD FIRST MAJESTIC	ELMD ELECTROMED, INC.	DT dynatrace	UARS USA Rare Earth	KLAR Klarna	FIG Figma	MSTC MAS TECH DIGITAL	
B BARRICK	PLUG Plug	VGS VENTURE GLOBAL	AEYE audioeye	EOSE eos	AGST Aqvestive	FRM FERMI AMERICA	UNUS UNUSUAL MACHINES	PAVM PAVmed	
MOSI Mosaic	MARA MARATHON	JD JD.COM	STXS STEREOTAXIS	ICL ICL	ASM AVINO	BLSH Bullish	USAC USAC	AZI CustMate	
CRON CRONOS GROUP	ARCH ARCHER	DOCN DOCN	PAYS paysign	GLBE Global e	DOCS doximity	INTU INTUITIVE MACHINES	BLZE blaze	SACH SUPER LEASE	
CGDD CARLYLE	CLSK CLEANSPARK	SEA sea	NXT NEXT POWER	TSEM Tower Semiconductor	GRAB GRABAGUN	SBC SBC	RUM rumble	SACH SACHEM	
LOGA Liquidia	BW BARCOCK & WILCOX	BETA BETA TECHNOLOGIES	FNV Franco-Nevada	VLEN Valens	STUB StubHub	TERE TERRESTRIAL ENERGY	NIN NEXTNAV	RBCB Suncrete BEARINGS	
XGN Exagen	QUBT QUBT	ACRX Acura Pharmaceuticals	OPRX Optimize Rx	VSHY VISHAY	FLNT FLUENT	YETI YETI	PED PEDEVCO	RBCB RBC BEARINGS	
TLS Telos	QDQ QUANTUM COMPUTING INC	ACHV ACHIEVE LIFE SCIENCES	GCT GCT	WIX WIX	FOSS FOSSIL GROUP	VIK VIKING	SPCE GLOBELECTRIC		

http://eps.sh/cal © 2026 Earnings Whispers